



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 5/44

Чингис хот

С.Лхагвачулууныг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2, Засгийн газрын 2019 оны 274 дугаартай “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” тогтоолын хавсралт, 277 дугаартай “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтний сул орон тоонд ажлын зайлшгүй шаардлагаас хамааран төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй С.Лхагвачулууныг 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтнээр томилон ажиллуулсугай.

2. Ажил хүлээнцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Ж.Гантулга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
дарга

Гишүүд:

Б.Мөнхжаргал

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин  
аялал жуулчлалын бодлого хариуцсан  
мэргэжилтэн

Т.Бямбадулам

Архив бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

3. С.Лхагвачулууны цалинг Т3-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 594803 /таван зуун ерэн дөрвөн мянга найман зуун гурав/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогчийн албан үүргийг хавсран гүйцэтгэг /Б.Оргодолд/-д зөвшөөрсүгэй.

4. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг С.Лхагвачуунд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

